



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/17

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Коронавируст "Ковид-19"-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор XVII жарны цагаагчин үхэр жилийн "Сар шинийн баяр"-ыг нийтээр тэмдэглэхгүй байхыг сумдын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгож, нийт иргэдэд уриалсугай.

Гурав. Захирамжийг хэрэгжүүлж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр нь танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481218840